



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

┌ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн ┐  
63.1.11 дэх заалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхийг олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 16.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.11-д заасан Хорооны бүрэн эрхийг хэрэгжүүлэхийг Хорооны дарга /Д.Баярсайхан/-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ өөрийгөө зохицуулах байгууллага, зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм, журмын төслийг батлах зөвшөөрлийг Хорооны саналын хамт албан бичгээр хүргүүлж байхыг Хорооны дарга /Д.Баярсайхан/-д үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 72.2-д заасны дагуу баталсан дүрэм, журмаа Хороонд бүртгүүлж байхыг өөрийгөө зохицуулах байгууллагуудад үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН